



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар

A/70

Хэрлэн сум

Түүхийн ном бүтээх ажлын хэсэг
байгуулж, ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, түүхийн ном бүтээх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)

Гишүүд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хяналт, дүн шинжилгээ, хууль эрх зүйн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Архивын тасгийн дарга

Аймгийн Музейн захирал

Аймгийн Нийтийн Номын сангийн Захирал

Хэнтий аймгийн иргэн, доктор (Ph.D), профессор Б.Цогтбаатар (зөвшилцсөнөөр)

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D) Н.Саруул (зөвшилцсөнөөр)

Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн захирал Г.Эрэгзэн (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн
дарга:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

2.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн

2.100 жилийн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, ном бүтээх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, энэхүү ажилд эрдэмтэн судлаачид, байгууллага, олон нийт, талуудын оролцоог ханган, түүхийн бодит баримт, судалгаанд үндэслэн ажлыг 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөрт багтаан хэрэгжүүлж, тайлагнахыг Ажлын хэсэг (С.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн ажиллах зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ